



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 14

Мандалговь

**С.Цэрэнрагчааг Дэрэн сумын Засаг даргын
Тамгын газрын Санхүүгийн албаны даргын
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Сэрдамбын Цэрэнрагчаа 76.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа С.Цэрэнрагчаагийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн
албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн
С.Цэрэнрагчаагийн тухай дүгнэлт**

1. С.Цэрэнрагчаа нь 1983 онд Дундговь аймгийн Дэрэн суманд төрсөн. 39 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2004-2008 онд "Санко" менежментийн дээд сургуулийг санхүүгийн менежмент мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2007-2009 онд Дэрэн сумын Соёлын төвийн номын санч, 2009-2011 онд иргэний бүртгэл хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан, 2012-2017 онд Дэрэн сумын Улсын бүртгэгч, 2020-2021 онд газрын даамал, 2021 оноос Луус сумын Улсын бүртгэгчээр ажиллаж байсан.
4. С.Цэрэнрагчаагийн төрийн албаны туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ